



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/687

Булган сум

Өсвөрийн үндэсний бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг, тамирчдад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.7 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2025 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардал шинэчлэн батлах тухай” А/648 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймагт 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөс 2025 оны 11 дүгээр сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулагдах өсвөр үеийн үндэсний бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээнд аймаг, орон нутгаа төлөөлөн оролцох баг, тамирчдын шатахууны зардалд 1,200,000 (нэг сая хоёр зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг “Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

0325010957

Дугаар А/687 2025 оны 10 сарын 29 өдөр Дорнод 2025/Захирамж